



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/299

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.1.1.3, 1.1.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинжлэх ухааны академийн Угсаатан судлал, биет бус өвийн төвөөс Өвөрхангай аймгийн Хужирт сумын нутагт хийх Хээрийн судалгааны ажлын удирдамжийг 1 дүгээр, тус судалгааны ажлын зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хужирт сумын нутагт хийх угсаатан зүйн судалгааны ажилд 2,896,500 (хоёр сая найман зуун ерэн зургаан мянга таван зуу) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Тус угсаатан зүйн судалгааны ажлыг зохион байгуулалтаар хангаж, үр дүнг танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




А.ИШДОРЖ

6223 11 0574

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар
сарын 02-ны өдрийн 1 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



Удирдамж

Шинжлэх ухааны академийн угсаатан судлал, биет бус
соёлын өвийн төвөөс өвөрхангай аймгийн хужирт сумын
нутагт хийх хээрийн судалгааны ажлын тухай

2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр

Арвайхээр сум

Судалгаа хийх бүс нутаг: Өвөрхангай аймгийн Хужирт сум

Чиглэл: Өвөрхангай аймгийн Хужирт сумын Өвөр модот, Уужим, Бэрх, Шивээт,
Шунхлай, Дулаан зэрэг 6 багийн нутаг. Хужирт сумын нийт хүн ам 7,000.

Судалгаа хийх хугацаа: 9 хоног

Судалгааны багийн бүрэлдэхүүн:

Судалгааны багийн ахлагч: Н.Маралмаа

Судалгааны багийн гишүүн: С.Пүрэвжав (ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн
Угсаатан судлал, биет бус соёлын өвийн төвийн эрдэм
шинжилгээний ажилтан)

Судалгааны багийн гүйцэтгэх үүрэг: Өвөрхангай аймгийн Хужирт сумын түүх, аж
ахуй, соёлын өвийн судалгааг хийж, аман түүх, эх хэрэглэхүүн цуглуулна.

Судалгааны ажлын үндэслэл:

Өвөрхангай аймгийн Хужирт сумын төв нь Улаанбаатар хотоос 390 км, аймгийн төв
Арвайхээр хотоос 90 км зайтай оршдог. 1246 оны улаан морин жилийн намар Өгэдэй
хааны хүү Гүюг Их Монгол улсын хаан ширээнд өргөмжлөгджээ. Энэхүү хаан ширээнд
өргөмжилсөн газрыг Ромын папаас элчээр ирсэн Плано Карпини Гүюгийг хаан ширээнд
залах ёслол Өгэдэйн хуучин зуны ордон болох Шар ордонд болсон гэж заасан байдаг.
Персийн түүхч Жувейнигийн бичсэнээр, Шар ордон нь эргэн тойрон тунгалаг сайхан горхи
булагтай, өтгөн өвстэй, уул нь модтой байжээ. Плано Карпини “Үзэсгэлэнтэй сайхнаараа
магтуулдаг Хархорум хэмээх хот бидний байсан Шира /Шар/ ордоос ойролцоогоор хагас
өдөрчийн зайд байсан боловч бид очиж үзэж чадаагүй” гэж бичжээ. Дээрх Шар ордон
байрлаж байсан газрыг зарим түүхчид Өвөрхангай аймгийн Хужирт сумын нутагт буй гэсэн
санал гаргажээ. Иймээс энэхүү хээрийн судалгаа нь тус сумын аж ахуй, соёлын дурсгал,
тухайн бүс нутгийн зан заншлын онцлогийг судлан, баримтжуулахад чиглэгдэх болно.

Судалгааны ажлын үр дүн: Угсаатны зүйн хээрийн шинжилгээний эх
хэрэглэгдэхүүн хуримтлуулна. Энэхүү хээрийн судалгааны хэрэглэгдэхүүнд дараах
зүйлийн агуулга багтаж, учир шалтгаант холбогдлыг тогтооно.

Үүнд:

Уул усны домог түүх, түүхэн газруудын судалгаа

Гэр орон сууц, хувцас, гоёл чимэглэл, хоол хүнс зэрэг эдийн соёлын зүйлс

Мал аж ахуйн тоног хэрэгсэл, им тамга зэрэг мал аж ахуйтай холбогдох, ан
гөрөө, тариалан, гэр зуурын үйлдвэрлэл зэрэг аж ахуйтай холбогдох
хэрэглэгдэхүүн

Хурим найр, баяр ёслол, уул овооны тахилга, шүтлэг бишрэл зэрэг оюуны
соёлд холбогдох хэрэглэгдэхүүн зэрэг болно.

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар
сарын 12-ны өдрийн 12/2023 дугаар
захирамжийн хавсралт



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХУЖИРТ СУМЫН НУТАГТ ХИЙХ
УГСААТАН ЗҮЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗАРДАЛ

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт
1.	Эрдэм шинжилгээний ажилтны хөлс	Хүн	2	1,448,250	2,896,500
Дүн					2,896,500

-oOo-